

БАТЛАВ.УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТОХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **Г. БАЯРСАЙХАН****ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ**

Олгосон огноо: 2023/11/30

Дугаар № 461/2023

Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр хаяг:

Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар ТБАГ

2. Барилгын байршил, мэдээлэл:

Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Сувдан сондор хотхоны урд талд, 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга

3. Холбох нөхцөл

Амгалан дулааны станцын өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэж бүрэн ажиллагаанд залгагдсаны дараа холбогдох.

4. Холбогдох цэг, байршлын зураг, схем, техникийн өгөгдөл:

12г магистраль, ДХ1262 худгаас холболттой салаа шугамын нам талаас 336/2023 тоот техникийн нөхцөлтэй уяалдуулан ойр орчмын нэгдсэн төлөвлөлттэй уялдан холбогдох.

-Холболтын цэг дээр байх түрэлт	10	м
-Шугамын статик даралт	40	м.у.б
-Буцах шугамын даралт	5.5	ата
-Гадна агаарын тооцоот температур	-39	0 С
-Температурын график	135/70	0 С

5. Дулааны эрчим хүчний хэрэглээ:

Нийт :	0.28	Гкал/цаг
А.Халаалт	0.14	Гкал/цаг
Б.Хэрэгцээний халуун ус	0.14	Гкал/цаг
В.Салхилуулга	0.00	Гкал/цаг

6. Дулаан дамжуулах, түгээх сүлжээ, дулаан дамжуулах төв, дулааны узель болон тоноглолд тавигдах шаардлага:

6.1 “Гадна дулаан хангамж” БНБД 41-02-05 -ийн 10.7-д заасны дагуу Дулаан хангамжийн хаалттай системийн үед халуун ус ба халаалтын хамгийн их дулааны ачааллын харьцаанаас хамааруулан ус халаагчийн холболтын схемийг сонгох.

Төлөвлөж буй барилгад төвлөрсөн дулаан хангамжийн техник ашиглалтын шаардлага хангасан халаалтын цогц төхөөрөмж суурилуулах.

Төлөвлөж буй байршилд ОСНААУГ болон бусад байгууллагын эзэмшлийн шугам сүлжээ байрлаж байгаа эсэх талаар тодруулга авч зураг төслийн шатанд зөвшилцөх.

6.2. Горим ажиллагаа доголдож хүндрэлтэй нөхцөл үүссэн үед өөрсдийн барилгын дулаан хангамжийн найдвартай байдлыг хангах нэмэлт эх үүсвэр төлөвлөж байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах.

6.3 Барилгын дотор халаалтын системд балансын хаалт, термостат суурилуулах.

6.4 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах шугам хоолой, тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи байх.

7. Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага:

7.1. Дулааны эрчим хүчний тооцоонд “Хэмжил зүйн тухай хууль”-ийн 9, 10 дугаар зүйлийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилт, улсын баталгаажуулалтад хамрагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн, дулааны тоолуурын лабораториор шалгагдсан, баталгаажуулалтын гэрчилгээ бүхий тооцооны хэмжих, тооцох хэрэгслийг суурилуулна.

7.2. “Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм”-ийн 6 дугаар бүлэгт заасны дагуу хангагч “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас дулааны эрчим хүчийг хэмжих тооцох хэрэгслийг суурилуулах техникийн нөхцөл авах

8. Зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлага:

8.1 Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 2.2-т заасан дамжуулах төв, дулааны шугамын хамгаалалтын зайг мөрдөн, барилга байгууламжийг төлөвлөх, мөн дүрмийн 2.6, эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т заасны дагуу хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, гэр хашаа барих, барилгын тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.

8.2. Дулааны шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.

8.3. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох явцад трассын дагуух зам талбай, ногоон байгууламжийг сэргээх, тохижилт хийх болон дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын түршилт хийх зардлыг төсөвт тусгах.

8.4. Гадна дулааны шугам хоолой болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм нормативд нийцсэн материалаар техникашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.

8.5. Дулааны шугам сүлжээ авто зам доогуур огтлох нөхцөлд нэвтрэх сувагтай байхаар төлөвлөн, зураг төсөвт тусгах.

8.6. Гадна дулааны шугам сүлжээний зураг төслийг боловсруулан хангагч байгууллага “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-тай зөвшилцөн, хянуулж, батлуулан 1%-г хүлээлгэн өгөх.

9. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам:

9.1. Дулааны шугам сүлжээ, тоноглолын зураг, төсөв боловсруулах, барилга угсралт, түршилт, тохируулгын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад дараах хууль, дүрэм, журам, барилгын норм ба дүрэм, стандартуудыг мөрдөж ажиллана.

9.1.1. Эрчим хүчний тухай хууль

9.1.2. Барилгын тухай хууль

9.1.3. Хэмжил зүйн тухай хууль

9.1.4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”

9.1.5. Дэд бүтцийн сайдын 2003 оны 125 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”

9.1.6. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 127 дугаар тушаалаар баталсан “Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”

9.1.7. Эрчим хүчний сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар баталсан “Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”

9.1.8. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290 дүгээр тогтоолоор баталсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний “Холболтын журам”

9.1.9. Барилгын норм ба дүрмүүд

9.2. Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Эрчим хүчний дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна”, мөн хуулийн 30.1.13-т “нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх” гэж заасны дагуу хангагч байгууллагад хүлээлгэн өгөх, шилжүүлэх нөхцөл хангасан тохиолдолд дулааны эрчим хүчээр хангана.

9.3 Эрчим хүчний тухай хуулийн 29.1.9-д “Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй” гэж заасан, мөн хэрэглэгч нь хуулийн 30.1.10-т “түгээх, зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах” гэж заасны дагуу бусад хэрэглэгчийг

9.4 Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 5.1.20-р заалтын дагуу дулаан дамжуулах 200мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугам, түүний анхдагч таслах хаалт нь эрчим хүчний дамжуулах шугам тоноглол тул түүнийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 348 дугаар тогтоолын дагуу 2Ø200мм-ээс дээш голчтой дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэх “Өмч шилжүүлэх гэрээ”-г байгуулж, хэрэгжилт бүрэн хангасан нөхцөлд

10. Техникийн нөхцөл олгосон үндэслэл:

Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2020 оны 12 сарын 30-ний өдрийн ГБМЗХ2020/36-20 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг үндэслэв.

11. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа:

11.1 Энэхүү техникийн нөхцөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд буюу 11/30/2025 өдрийг хүртэл хүчинтэй.

11.2. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ.

11.3. Тус дүрмийн 2.7-д заасны дагуу техникийн нөхцөлийн хугацааг боломжтой тооцооны дүн гарсан тохиолдолд 1 удаа 1жилийн хугацаатай сунгана.

11.4. Техникийн нөхцөлийн 3 болон 11 дэхь заалт хангагдаагүйгээс хэрэглэгч холбогдоогүй тохиолдолд техникийн нөхцөл олгосон хангагч байгууллага хариуцлага хүлээхгүй.

11.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийг үндэслэн зураг төслийн байгууллагаар барилга угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төслөө хийлгэж, холбогдох байгууллагуудаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

11.6. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ. Хэрэв зураг төслийг батлуулаагүй, мөн баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн

12. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох:

12.1. Дараах тохиолдолд энэхүү техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

12.1.1. Хүчинтэй хугацаа дууссан;


12.1.2. Энэхүү техникийн нөхцөлийн аль нэг заалт, шаардлагыг биелүүлээгүй

12.1.3. Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

12.1.4. Олгосон ачааллаас хэтрүүлэн чадал ашигласан, мөн холболтын цэгийг өөрчилсөн тохиолдолд;

12.2. Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламжийг дулаанд холбохыг хориглоно.

ЗӨВШӨӨРСӨН.
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Ш.МӨНХЖАРГАЛ

ХЯНАСАН:
ҮХХ-ИЙН ДАРГА

Б.ЭРДЭНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
ҮХХ-ИЙН ИНЖЕНЕР

Н.САНЖААЖАМЦ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээдийг төлөөлж:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн шаардлагууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалтга танилцсан эсэх

ТИЙМ

ҮГҮЙ

Нэр *Баясүндэрлэ ХХК*

Гарын үсэг *Б.Эрдэнэбаяр*

Регистрийн дугаар *6077196*

Холбоо барих

Огноо 2024 он *2* сар *5* өдөр



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
Дугаар D-U2024/225

Захиалагч байгууллага:	НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
Хэрэглэгчийн нэр:	А.УЯНГА
Харилцах утас:	99829656,88843348
Байршил:	БЗД 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт
Зориулалт:	Цэцэрлэгийн барилга
Холбооны хэрэгцээ:	СУВАГЧЛАЛ ХИЙХ

- 1. Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцөлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга объектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
- 2. Техникийн үндсэн нөхцөл:**
 - 2.1 КШТ 45, ХШ 4524 хүрээний М1 3-5-16-10 худгаас гол сувагчлалыг $\varnothing 110\text{мм}$ -н **4+0** эгнээ сувагчлалын хоолой, салбар сувагчлалыг барилга хүртэл $\varnothing 110\text{мм}$ -н **2+0** эгнээ сувагчлалын хоолой суурилуулах ба шинээр хийх сувагчлалыг 0.8-1.0 метрийн гүнд суурилуулна.
 - 2.2 Сувагчлал хооронд худаг суурилуулах зай хэмжээг 120 метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба эргэлт болон барилгын оролтод зайлшгүй стандартын худаг суурилуулна.
 - 2.3 Шинээр суурилуулах сувагчлал нь авто зам болон бусад инженерийн шугам сүлжээтэй хөндлөн өгтлөлцсөн тохиолдолд хамгаалалтын ган хоолойд сувагчлалыг сүвлэж хамгаална.
 - 2.4 Шилэн кабель татах асуудлыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, бусад үйлчилгээ эрхлэгч оператор компаниудтай тохиролцож шийдвэрлэх.
Дохиолол, домофон систем, телефон холбоо, кабелийн телевиз, интернэт, хяналтын систем, шинэ үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийг байршуулах техникийн өрөөг зайлшгүй төлөвлөх шаардлагатай.
- 3. Зураг төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцөлүүд:**
 - 3.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт **MNS 6305:2012** Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл, **MNS 4908:2022** Мэдээлэл, холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ, **MNS 5532:2022** Мэдээлэл, холбооны дотоод сүлжээ дохиолол, хяналтын системийн төхөөрөмжийн тэмдэглэгээ, ерөнхий шаардлагууд болон "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5-р зүйлд заасны дагуу гүйцэтгэх.
 - 3.2 Төлөвлөж буй барилгын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан авто зам, авто зогсоолын талбайд одоо байгаа худаг сувагчлалын байгууламж хөндлөн болон дагуу таарсан тохиолдолд хүчитгэж хамгаалахаар тусгаж өгөх.
 - 3.3 Дээрх техникийн нөхцөлийн дагуу гадна холбооны ажлын зураг гүйцэтгэхдээ Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсээр техникийн шийдлийг хянуулан, зөвшилцөж батлуулна. (Утас:70112383)

4. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 4.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.
- 4.2 Техникийн нөхцөл, ажлын зураг төсвийн дагуу угсралтын ажил эхлэхээс өмнө Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсээс ажил эхлэх зөвшөөрлийг авч тухайн ашиглалт хариуцсан газар, нэгжийн хяналтан дор гүйцэтгэнэ.
- 4.3 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ тухайн харъяалагдах Кабель шугамын тасгуудаар шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актан д хавсаргах.
- 4.4 Шинээр татсан кабель болон төгсгөлийн төхөөрөмжид хаягжилт бүрэн хийсэн байх.
- 4.5 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.
- 4.6 Угсралт суурилуулалт хийхдээ **MNS 6668:2017** "Холбооны худаг сувагчлалын байгууламжийн техникийн үзүүлэлт, суурилуулалтын шаардлага", **MNS 5017:2023** "Харилцаа холбооны сүлжээний сувагчлалд зориулсан хуванцар хоолой, техникийн шаардлага", **MNS 6597:2021** "Холбооны кабель шугамыг авто зам, төмөр замыг хөндлөн гаргах болон гүүрийн байгууламжаар дамжуулан суурилуулахад тавих ерөнхий шаардлага" стандартуудын дагуу гүйцэтгэх.
- 4.7 Шинээр хийгдсэн худаг сувагчлалын байгууламжийг "Шугам сүлжээний гүйцэтгэлийн зураглалыг шалгаж хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авсан акт", CD эсвэл DWG файл хэлбэрээр ашиглалтын байгууллагад хүлээлгэж өгсний үндсэн дээр худаг сувагчлалын гүйцэтгэлийн зургийг гаргуулна.

5. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

- 5.1 Шинээр суурилуулсан худаг сувагчлалын байгууламжийг гүйцэтгэлийн актаар хүлээлгэн өгснөөр ашиглалтын явцад гарах засвар үйлчилгээг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь хариуцна.
 - 5.2 Уг худаг сувагчлалын байгууламж нь цааш үргэлжлүүлэн төлөвлөх, засвар үйлчилгээ хийх, мөн харилцаа холбооны бусад үйлчилгээний зориулалтаар шилэн кабель шинээр суурилуулах зэрэг нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
6. **Техникийн нөхцөлийг:** Бат сүндэрлэ ХХК-ийн захирлын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 24/16 тоот албан бичиг болон D-U2023/895 тоот техникийн нөхцөлийг үндэслэн олгов.
7. Угсралтын ажил дууссаны дараа Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн хариуцсан нэгжээр хэмжилт шалгалт хийлгэж, техникийн актаар хүлээлгэн өгснөөр сүлжээнд холбогдох боломжтой.
8. **Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцөлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалтыг олгоно.**

ТАНИЛЦСАН:


ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



А.ГАНТУЛГА

С.ЗОЛЖАРГАЛ



М.ЖАРГАЛАН

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/01434/23

2023 оны 10 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	Хүсэлтийн дугаар	231001235
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, РД:9095489
1.3	Хэрэглэгчийн байршил:	Баянзүрх дүүргийн 14-р хороо
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Цэцэрлэг
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1.5.1) Газар эзэмших эрхийн 2023 оны нэгж талбарын 1330801422 дугаартай гэрчилгээ 1.5.2) Баянзүрх дүүргийн засаг даргын тамгын газрын 2023 оны 02/2822 дугаартай албан бичиг 1.5.3) Бат сүндэрлэ ХХК-ийн 2023 оны 05 дугаартай албан бичиг
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Суурилагдсан хүчин чадал	182 кВА (Нэг зуун наян хоёр кВА)
1.8	Хүчдэлийн түвшин	10кВ

Хоёр. Холболтын цэг

2.1	Дэд өртөөг: -110/35/10 кВ-ын Дүнжингарав дэд станц, ХБ-29-ийн 10 кВ-ын Цагаанхуаран А,Б фидерийн ХТП-1777 дэд өртөөний 10 кВ талын I ба II секцэнд ачаалал таслагч бүхий ячейк шинээр суурилуулан кабель шугам татаж тэжээх. - 35/10 кВ-ын Дорнод-1 дэд станцын 10 кВ-ын Төмрийн завод фидерийн гол кабель шугамыг тасалж ижил хөндлөн огтлолтой кабель шугамаар оруулж гарган шинээр баригдах дэд өртөөний 10 кВ талд холбох.
2.2	Цэцэрлэгийн барилгыг: Шинээр баригдах дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцээс кабель шугам татаж тэжээх

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орсон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.
3.2	Дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий оруулгуудад УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг

- дэмждэг, 4G модемтой, тасалж залгах команд өгөх боломжтой, 3 фазын ухаалаг тоолуур, гүйдлийн трансформатор болон тоолуураас өгөгдөл цуглуулж дамжуулах зориулалттай, 4G модемтой концентраторыг тусгай хайрцагт суурилуулах.
- 3.3** Цэцэрлэгийн 0.4 кВ талын ерөнхий щитэнд УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, HPLC технологийн модуль бүхий 3 фазын ухаалаг тоолуур, ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж /УЗО/, ачаалалд тохирсон гүйдлийн трансформатор суурилуулах.
- 3.4** Ажлын зураг төслийг зөвшилцөх шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг УБЦТС ТӨХК-аар хянуулсан байх.

Дөрөв. Тусгай заалтууд:

- 4.1** Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 2*250 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг /ХТП/ өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
- 4.2** Энэхүү техникийн нөхцөл нь дараах нөхцөл, шаардлагуудыг хангасан тохиолдолд хүчинтэй болно.
- 4.2.1) Энэхүү техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд түгээх сүлжээнд холбогдсон байх шаардлагатай.
- 4.2.2) Эх үүсвэр дэд станц, шугам тоноглол хэт ачаалагдсан тул түгээх сүлжээнд 2023, 2024 онд цахилгаан ачаалал нэмэх боломжгүй. Шугам сүлжээнээс 2025 онд 50 кВА чадлаас хэтрэхгүйгээр хангана.
- 4.2.3) Цаашид эх үүсвэр дэд станц, шугам тоноглолын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэний дараа олгосон бүрэн чадлыг үе шаттайгаар ашиглах боломжтой юм.
- 4.3** Өвлийн их ачааллын горимд тус цахилгаан ачааллыг залгах боломжгүй тул жил бүрийн 11-р сарын 01-ээс 03-р сарын 01 хүртэл ахуйн хэрэглээнээс бусад цахилгаан ачааллыг нэгдсэн системийн зохицуулалтаар хязгаарлах арга хэмжээ авах нөхцөлөөр энэхүү техникийн нөхцөлийг олгов.
- 4.4** Шинээр баригдах дэд өртөөний 10 кВ талын хуваарилах байгууламж нь 10-аас доошгүй ячейк суурилуулсан байх.
- 4.5** Дэд өртөөний барилга нь тоосгоор баригдсан байх шаардлагатай бөгөөд цаашид өргөтгөх боломжтой байхаар барих.
- 4.6** Одоо ашиглагдаж байгаа ХТП-ны 10 кВ талд шинэ ячейк суурилуулах зай байхгүй тохиолдолд тухайн дэд өртөөний барилгыг өртгөтгөх.
- 4.7** Галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах.
- 4.8** Шугам, дэд өртөөний гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа шугамын холболтын муфтуудыг заасан мөн бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.
- 4.9** 10/0.4 кВ-ын дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж нь трансформаторын хүчин чадлаар тооцогдсон таслах залгах тоноглол, хэт хүчдэл тусгаарлагч, гал хамгаалагч болон хүчний трансформатораар тоноглогдсон байна.
- 4.10** Дэд өртөөний 0.4 кВ талын хуваарилах байгууламж нь хэт хүчдлийн хамгаалалт, ихсэх гүйдлийн, хэт ачааллын, хүчдэл ихсэлт бууралтын, фазын нойл тасралт, фазын дараалал алдагдалтаас сэргийлсэн хамгаалалтуудаас тоноглогдсон

	байна.
4.11	Түгээх сүлжээний үндсэн шугам нь хэт урт, ачаалал ихтэйгээс шалтгаалан хэрэглэгчид очих эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх төхөөрөмж сууриуулах болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг УБЦТС ТӨХК-тай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Нэмэлт ажилтай холбоотой гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
4.12	Дэд өртөөний бүх тоноглол, гаргалга кабель шугамууд болон агаарын шугамын тулгуур бүрт НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.
4.13	УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.14	Хаалттай дэд өртөө рүү оруулж гаргах 10 кВ-ын кабель шугамуудыг зураг төсөл боловсруулах шатанд 2 өөр трасс сонгож зөвшилцөх.
4.15	Хаалттай дэд өртөө рүү орж гарсан 10 кВ-ын кабель шугам нь УБЦТС ТӨХК-ийн найдвартай ажиллагааны горим схем үүсгэдэг гол магистраль кабель шугам тул тус компанийн үндсэн хөрөнгө болохыг анхаарна уу.
4.16	Хаалттай дэд өртөөний газардуулга, аянга зайлуулагч болон шугам тоноглолыг норм дүрэм, зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх, холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
4.17	Цахилгаан дамжуулах шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцөн сонгох.
4.18	Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.
4.19	Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь: 4.19.1) Шинээр татах 10 кВ-ын кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх. 4.19.2) Шинээр татах 10 кВ-ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох, ашиглагч “УБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх. 4.19.3) Шинээр татах кабель шугам нь 10 кВ-ын хүчдлийн түвшинд ажиллах, гадна орчны температур -15 хэт байхад угсралт хийх боломжтой байх.
4.20	Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.
4.21	Өвлийн их ачааллын улиралд эрчим хүчний системийн горим ажиллагааг хангах үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр хязгаарлалт хийж болзошгүй тул нөөц эх үүсгүүрийг бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхаарна уу.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугам, дэд өртөөний “Ажлын зураг төсөл”-ийг ЦБД, ТАД, ААД, ГАБХД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
-----	---

- 5.2 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан “Техникийн шаардлагын тодорхойлолт”-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.
- 5.3 Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагч, богино залгааны гэмтэл заагч датчикийг суурилуулах. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.
- 5.4 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
- 5.5 “Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.13-д заасны дагуу нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж байгаа учир шинээр барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.
- 5.6 Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
- 5.7 “Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9 -д заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
- 5.8 “Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.
- 5.9 Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.
- 5.10 Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
- 5.11 “Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.12 Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 5.13 Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
- 5.14 Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
- 5.15 Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

- 6.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

- 6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд;
- 6.1.2) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд;
- 6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.
- 6.1.4) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.
- 6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.
- 6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.
- 6.2** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 6.3** Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.
-





ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/02150/24

2024 оны 6 сарын 4 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	Хүсэлтийн дугаар	240501351
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, РД:9095489
1.3	Хэрэглэгчийн байршил:	БЗД 14-р хороо 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Шугам, дэд станц зөөх
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1.5.1) УБЦТС ТӨХК-ны АЗЗТөвийн 2024 оны №02 тоот тодруулга 1.5.2) УБЦТС ТӨХК-ны КАЗТөвийн 2024 оны №44 тоот тодруулга 1.5.3) Газар эзэмших эрхийн 2023 оны нэгж талбарын 1330801422 дугаартай гэрчилгээ 1.5.4) Баянзүрх дүүргийн засаг даргын тамгын газрын 2023 оны 02/2822 дугаартай албан бичиг 1.5.5) Бат сүндэрлэ ХХК-ийн 2024 оны 24/29 дугаартай албан бичиг
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Суурилагдсан хүчин чадал	0 кВА (кВА)
1.8	Хүчдэлийн түвшин	380В

Хоёр. Холболтын цэг

2.1	
-----	--

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	,
-----	---

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Төлөвлөж байгаа хэсэгт дараах агаарын болон кабель шугам, тулгуурууд, дэд өртөө нь трасстай давхацсан, хөндлөн гарсан, ойртсон тул батлагдсан зургийн дагуу трасс өөрчлөн зөөх Үүнд:
-----	--

- 4.1.1) -0.4 кВ-ын агаарын шугам:
АТП-773 дэд өртөөний 0,4 кВ-ын урд гаргалгын тулгуур № 14,18,19,24,25,26 болон цахилгаан дамжуулах агаарын шугам трасст орсон тул эдгээр шугамыг батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх.
- 4.1.2) 6, 10 кВ-ын агаарын шугам:
- 35/10 Дорнод-1 дэд станцын 10 кВ-ын Төмрийн завод фидерийн тулгуур № 2 болон цахилгаан дамжуулах агаарын шугам трасст орсон тул агаарын шугамаар батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх.
- 4.1.3) 6, 10 кВ-ын кабель шугамууд:
- 35/10 Дорнод-1 дэд станцын 10 кВ-ын Төмрийн завод фидерийн тулгуур № 1 явсан 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам трасст орсон, ойртсон тул эдгээр шугамыг батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх.
- 4.2** Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын зөөх байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн Нийслэлийн барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
- 4.3** Цахилгаан дамжуулах агаарын шугамыг кабель шугамаар трасс өөрчлөн зөөх бол 2 талдаа хуурай салгуур бүхий алсын удирдлагатай, УБЦТС ТӨХК-ийн СКАДА системтэй холбогдож ажилладаг реклоузериин пункт суурилуулах. Реклоузериин пункт суурилуулах байршлыг ажлын зураг төслийн шатанд тус компанитай зөвшилцөх.
- 4.3.1) Шинээр суурилуулсан реклоузериин пунктийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р тогтоолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх
- 4.4** Нэг трассад байгаа кабель шугамуудыг Цахилгаан байгууламжийн дүрэм, ТАД, ААД-ын заалтуудыг хангасан инженерийн сувагчлалын байгууламж, кабелийн блок барьж байршуулах.
- 4.5** Инженерийн сувагчлалын байгууламж, кабелийн блок барих ажлын шийдэл төслийг тус компанийн Түгээх үйл ажиллагааны бодлого төлөвлөлтийн хэлтэстэй зөвшилцөх.
- 4.6** Кабель шугамыг шилжүүлэн зөөх хэсэгт байгаа муфтыны байршлын тодруулгыг харьяа ашиглалт засварын төвөөс авч, шугамыг муфтынаас муфтыны хооронд зөөх асуудлыг барилга угсралтын ажлын зураг төслийн шатанд УБЦТС ТӨХК-тай зөвшилцөж гүйцэтгэх.
- 4.7** Шинээр татах кабель шугам нь авто зам болон тохижилттой зам талбайгаар хөндлөн гарах тохиолдолд кабелийг ган хоолойнд сүвлэх ба тохижилттой зам талбайд авах боломжтой хавтан суурилуулах.
- 4.8** Батлагдсан зургийн дагуу зөөж шилжүүлэх шугамын трасс өөрчлөгдөх тохиолдолд харьяа ашиглалт засварын төвөөс дахин тодруулга авч УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх.
- 4.9** Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.
- 4.10** Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа ашиглалт засварын төвөөр хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
- 4.11** Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө бусад тоноглолыг УБЦТС ТӨХК-ийн харьяа ашиглалт засварын төвд актаар хүлээлгэн өгөх.

4.12	Буусан тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 2.7.2-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
4.13	Зөөж шилжүүлэх цахилгаан дамжуулах шугамын угсралтын зураг төслийг ЦБД-ийн БД 43-101-03-д заасны дагуу зай хэмжээг баримтлан гүйцэтгэх.
4.14	Газар шорооны ажил эхлэхээс өмнө УБЦТС ТӨХК-ийн харьяа ашиглалт засварын төвд хандаж дахин тодруулга хийлгэх, барилга угсралтын ажлын үед хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
4.15	УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцыг шилжүүлэн зөөх ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.16	Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт газар шорооны ажил хийгээгүй бол дахин тандалт хийлгэх.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугамын “Ажлын зураг төсөл”-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан “Техникийн шаардлагын тодорхойлолт”-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.4	“Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.
5.5	“Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.6	Нийслэлийн нутаг дэвсгэрт кабель шугам шинээр татах, шинэчлэх, засварлах үед авто зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн тохижилттой зам талбайг сэтлэх, сүвлэх инженерийн шугам сүлжээ хийх, орц гарц гаргах тохиолдолд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авах.
5.7	Шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.8	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.9	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх
-----	---

дүрэм"- ийн 2.17- д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд.

6.1.2) Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.

6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.

6.1.4) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно

6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.

6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.

6.2 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

6.3 Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.




БАТЛАВ
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

УСУГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын
2023 оны 10-р сарын 19-ний өдрийн хурлын
шийдвэрийг үндэслэн зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 694 \ 23

1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил	БЗД-ийн Засаг даргын тамгын газар, НБГазар, 240 хүүхдийн цэцэрлэгийн 2 давхар барилга, БЗД 14-р хороо, “Буянт-Од” хотхоны урд талд
2	Нийт усны хэрэглээ:	Цэвэр усны – 7,5 м ³ /хон Галын усны – 2,5 л/с Бохир усны – 7,5 м ³ /хон
3	Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Төвийн цэвэр усны Ф500 мм-ийн шугамнаас холболттой орчны хэрэглэгчийн шугамнаас холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх
4	Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Төвийн бохир усны 3-р гол цуглуулах Ф800 мм-ийн шугаманд холбогдсон орчны хэрэглэгчийн шугамын худагт холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх
5	Нэмэлт нөхцөл	Бусад шаардлага: <ul style="list-style-type: none"> ➢ Ус хангамж, ариутгах татуургын системийн угаалга, шахалт, туршилт тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах. ➢ Барилгын гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний холбох цэгийг өөрчлөх тохиолдолд хүсэлт тавьж хянуулан, хангагч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. ➢ Холбогдох Хууль, БНБД, стандартыг мөрдөх ➢ Гадна шугамын ажлын зургийг ХБХГ-тай зөвшилцөх ➢ Стандартын дагуу тос баригч суурилуулах
6	Тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 1.Барилгыг “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн дагуу цэвэр усны шугамын тэнхлэгээс 5 м, бохир усны шугамын тэнхлэгээс 6 метр зайд барих 2.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 15.1.10 –ын дагуу хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд батлагдсан ажлын зураг, төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах. 3.Борооны ус зайлуулах шугам сүлжээг тусад нь төлөвлөх, борооны усыг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх. 4.Цэвэр, бохир усны шугамын угсралт, шахалт туршилт, холболтын ажлын явцад ашиглалтын байгууллагын хяналтын инженерийг байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө. 5.Төвийн болон хэрэглэгчийн цэвэр, бохир усны худаг, шугам сүлжээн дээр болон хамгаалалтын бүсэд зам талбай, авто зогсоол, барилгын довжоо, хүүхдийн тоглоомын талбай зэргийг төлөвлөсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийх боломжийг бүрдүүлэх, засварын дараахь нөхөн сэргээлтийн ажлыг өөрсдөө хариуцах 6.Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа 2 жил.
7	Объект барих дээд газрын шийдвэр:	<ul style="list-style-type: none"> ➢ Газар эзэмших эрхийн 0000211456 дугаартай гэрчилгээ ➢ ГБМЗХ2020/36-020 тоот архитектур төл-тийн даалгавар
8	Хэрэглэгчийн нэр, утас:	БЗД-ийн ЗДТГазар, Утас: 266359

